

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/26-18-ШТА-ГА

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463

Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ч.Загдсүрэн Утас: 70272582

Цахим хаяг: zagdsurench@audit.gov.mn

Аудитор С.Намшир Утас: 70272582

Цахим хаяг: namshirs@audit.gov.mn

Аудитор Г.Хатанбаатар Утас: 70272582

Цахим хаяг: khatanbaatar@audit.gov.mn

Аудитор Г.Ариун-Уянга Утас: 70272582

Цахим хаяг: ariun-uyangag@audit.gov.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.	4
1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.	6
1.1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн нийт эх үүсвэр 2024 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 2,318.6 сая төгрөг дутуу буюу 92,9 хувийн гүйцэтгэлтэй төвлөрчээ.	6
1.2. Аймгийн ОНХС-ийн төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулж төлөвлөсөн боловч иргэдтэй нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй, харин сум, багийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, оролцоотой төлөвлөжээ.	8
2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга, зорилго зорилтыг бүрэн тодорхойлоогүй, тооцоо судалгаа дутуу хийгдснээс тоног төхөөрөмж худалдан авахаас өөр ажил хийгдээгүй, үр дүнгүй байна.	12
2.1. Сумд нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах, гэрээ байгуулсан өдрөө буюу ажлын гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилтийн 40-100 хувийг урьдчилгаагаар олгосон байна.	12
2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, зорилго, зорилтыг тодорхойлж, тооцоо судалгаа хийгээгүйгээс тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж, тухайн төсөл, хөтөлбөр зорилтот түвшинд хүрээгүй, үр ашиг, үр дүнгүй байна.	18
2.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.	21
3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагч хяналт тавьдаг боловч зөрчил дутагдлыг арилгаагүй байна.	22
3.1. ОНХС-аас хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан бөгөөд захиалагчийн зүгээс хяналт тавьдаг боловч зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	22
3.2. Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн цахим системд хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг дутуу мэдээлсэн байна.	24
Дүгнэлт:	26
Зөвлөмж:	27
Холбогдох байгууллагын санал:	26

Хүснэгтийн товъёог

Хүснэгт №1	Төв аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөгөө
Хүснэгт №2	Улсын төсөв болон ОНХНС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл
Хүснэгт №3	Орон нутгийн өөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
Хүснэгт №4	Аймаг, сумын ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ
Хүснэгт №5	Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийн ХАА-ны судалгаа

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УМС	Удирдлага мэдээллийн систем
ҮАГ	Үндэсний аудитын газар
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ПТК	Политехникийн коллеж

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол болон Монгол улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаал, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хийлээ.
Аудитын зорилт	Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж гарган, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр хийлээ. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх, • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх, • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамрууллаа.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сум, багийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын БОНХОБТХ, СТСХ, аймгийн ОНӨГ, Худалдан авах ажиллагааны газар зэрэг байгууллага, аймаг, сумдын ОНХС-ийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	Байхгүй.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, MNS 6817-5:2020, MNS 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горим хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, боловсруулан зөвлөмж бэлтгэв. Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. ▪ Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт

- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоол.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ч.Загдсүрэн, Г.Ариун-Уянга, Г.Хатанбаатар, С.Намшир нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 8 дугаар сарын 15-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2025 оны 8 дугаар сарын -ны өдөр Дархан аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх хугацаанд төлөвлөгөөт бус 1 аудит хийж, 1 аудитын судалгааг холбогдох газруудаар гаргуулж нэгтгэн УАГ-т хүргүүлсэн. Аймаг, сумын ОНХС-ийн зарцуулалттай холбоотой зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнууд ихэнх нь тухайн албан тушаалаасаа халагдсан, өөрчлөгдсөн тул хариуцлага тооцох албан шаардлага бичих боломжгүй болсон байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн нийт эх үүсвэр 2024 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 2,318.6 сая төгрөг дутуу буюу 92,9 хувийн гүйцэтгэлтэй төвлөрчээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4¹, 60.2.9²-өөс бусад эх үүсвэрээс 2024 онд 32,636.2 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс харилцах дансны урд оны үлдэгдэл 4,315.4 сая төгрөг, бүгд 36,951.6 сая төгрөгийг эх үүсвэрт төлөвлөсөн байна.

Хүснэгт №1: Аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөгөө

						/мян.төг/
№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь	
	ОНХСангийн харилцах дансны эхний үлдэгдэл	4,315,449.2	4,315,449.2	0		
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1 орсон/	24,838,049.4	23,866,852.0	971,197.40	96.1	
2	ОНХНС болон улсын төсөв					
	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	179,762.0	179,762.0	-	100.0	
	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	1,130,236.0	1,130,236.0	-	100.0	
3	"Тогтвортой амжиргаа-3" төсөл /ТТХ-ийн 59.1.3/	2,218,711.0	2,218,711.0	-	100.0	
4	ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"	-	-			
5	Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр					
	ТТХ-ийн 60.2.5 "тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"	2,558,111.4	1,679,358.7	878,752.70	65.6	
6	Бусад орлого	-	113,838.9	(113,838.90)		
7	Малын тоо толгойн албан татвар	1,711,344.8	1,128,808.5	582,536.30	66.0	
	Нийт орлого	32,636,214.6	30,317,567.1	2,318,647.5	92.9	
	Аймгийн ОНХС-ийн эх үүсвэр бүгд	36,951,663.8	34,633,016.3	2,318,647.5		

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Улсын төсөв болон ОНХНС-аас Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын хоёрдугаар зүйлд заасны дагуу ОНХНС-ын эх үүсвэрийг бүрдүүлж, аймгийн ОНХС-г 3 эх үүсвэрээс 28,366.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 27,395.6 сая төгрөгийг хуваарилж, санхүүжүүлсэн байна. Улсын төсөв буюу ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг төлөвлөгөөнөөс 971.2 сая төгрөгөөр дутуу, 96,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

¹ "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"

² "Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж"

Хүснэгт №2: Улсын төсөв болон ОНХНС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл

/мян.төг/

№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1 орсон/	24,838,049.4	23,866,852.0	971,197.4	96.1
2	ОНХНС болон улсын төсөв				
	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	179,762.0	179,762.0	-	100.0
	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/	1,130,236.0	1,130,236.0	-	100.0
3	"Тогтвортой амжиргаа-3" төсөл /ТТХ-ийн 59.1.3/	2,218,711.0	2,218,711.0	-	100.0
БҮГД		28,366,758.4	27,395,561.0		96.6

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Орон нутгийн өөрийн орлогод 2 эх үүсвэрээс 4,269.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4-д заасан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрт орлого төлөвлөөгүй бол 60.2.5-д заасан хандив тусламжийн орлогоор 2,558.1 сая төгрөг төлөвлөсөн нь өөрийн орлогын 60,0 хувь болсон байна. Мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан малын тоо толгойн албан татварын орлогоор сумдад 1,711.3 сая төгрөг төлөвлөжээ.

Хүснэгт №3: Орон нутгийн өөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

/мян.төг/

№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"	-	-		
2	Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр				
	ТТХ-ийн 60.2.5 "тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг"	2,558,111.4	1,679,358.7	878,752.70	65.6
3	Бусад орлого	-	113,838.9		
4	Малын тоо толгойн албан татвар	1,711,344.8	1,128,808.5	582,536.30	66.0
ДҮН		4,269,456.2	2,922,006.1	1,461,289.0	68.4
5	ОНХСангийн харилцах дансны эхний үлдэгдэл	4,315,449.2	4,315,449.2		
БҮГД		8,584,905.4	7,237,455.3	1,461,289.0	84.3

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Аймгийн өөрийн орлогын эх үүсвэр нь урд оны харилцах дансны үлдэгдэл 4,315.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хандив тусламжийн орлого 1,679.4 сая төгрөг төвлөрсөн нь 878.8 сая төгрөгөөр, малын тоо толгойн татвар 1,128.8 сая төгрөг төвлөрсөн нь 582.5 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу байна. Эдгээр орлого төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн нь ой, баяр наадам тэмдэглэх зарим сумдууд хандив,

тусламжийг өндрөөр төлөвлөсөн, мөн малын тоо толгойн татварыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн төвлөрүүлээгүйгээс гадна сумын малын тоо толгойн албан татварын дансанд төвлөрсөн 357.3 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй Батсүмбэр 99.9 сая төгрөг, Баян-Өнжүүл 93.9 сая төгрөг, Сэргэлэн сум 50.5 сая төгрөг гэх мэт 14 сум байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ, 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого" гэсэн заалтыг зөрчжээ. Мөн Баянжаргалан сум малын тоо толгойн татварын орлогыг төлөвлөөгүй боловч 57.7 сая төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлжээ. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.7-д "сум, дүүргийн ИТХ малын тоо толгойн албан татварын тухайн жилийн орлогыг тооцон батална" гэснийг зөрчсөн байна.

Зарим сум сумын ой тэмдэглэхтэй холбоотой хандив, тусламжийн орлого төлөвлөсөн нь дутуу төвлөрчээ. Тухайлбал: Батсүмбэр сум 950.0 сая төгрөгөөс 701.8 сая төгрөг, Бүрэн сум 800.0 сая төгрөгөөс 393.8 сая төгрөгийн хандив, тусламж төвлөрсөн байна.

Үүнээс гадна төлөвлөгдөөгүй 113.8 сая төгрөгийн бусад орлого орсон нь Эрдэнэ сум түрээсийн орлого 46.2 сая төгрөг, мөн аймгийн ОНХС-аас 2023 оны жилийн эцэст чанарын баталгааны дансанд төвлөрүүлсэн орлогоос 57.7 сая төгрөгийг буцааж төвлөрүүлжээ.

ОНХС-ийн орон нутгийн өөрийн орлого буюу аймаг, сумын ОНХС-д төвлөрүүлэх орлого 1,347.5 сая төгрөгөөр дутуу төвлөрч 84,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймаг, сумдын ОНХС-д Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу тооцож, хуваарилсан санхүүжилтийг ОНХС-аас аймаг, сумдад хуваарилжээ.

Аймгийн ОНХС-д 2024 онд нийт 32,636.2 сая төгрөг төвлөрөхөөс 30,317.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь 2,318.6 сая төгрөгийн орлого дутуу буюу 92,9 хувийн биелэлттэй байна.

Улсын төсөв болон ОНХС-аас 28,366.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдснаас 971.2 сая төгрөгөөр дутуу буюу 27,395.6 сая төгрөг хуваарилагдаж санхүүжснээс 10,132.5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, үлдсэн 17,263.1 сая төгрөгийг 27 суманд Сангийн яамнаас хийсэн хуваарийн дагуу санхүүжүүлжээ. Аймгийн ОНХС 529.2 сая төгрөгөөр, сумдын ОНХС 442.0 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Аймгийн төсөвт аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолоор тодотгол хийгдэж ОНХС-ийн орлогын шилжүүлэг 28,366.8 сая төгрөг, үүнээс

- аймгийн ОНХС-нд 10,661.8 сая төгрөг,
- сумдын ОНХС-нд 17,705.0 сая төгрөгийг Сангийн яамнаас ирүүлсэн

тооцооллыг үндэслэн аймгийн ИТХ-ын тогтоолоор баталж, санхүүжүүлсэн байна.

1.2. Аймгийн ОНХС-аас хэрэгжих төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулж төлөвлөсөн боловч иргэдтэй нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй, харин сум, багийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, оролцоотой төлөвлөжээ.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйлд багийн түвшинд, 6 дугаар зүйлд сумын түвшинд ОНХС-г төлөвлөхөд олон нийтийн оролцоог хангах талаарх зохицуулалт тусгагдсан.

Багийн түвшинд журамд заасан хугацаанд ИНХ хуралдуулж, иргэдийн гаргасан саналыг нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлснийг тодорхой аргачлалаар боловсруулж, эрэмбэлсэн жагсаалт гарган сумын Засаг даргад хүргүүлж ажилласан байна. Багийн ИНХ-аар иргэдээс саналын хуудас буюу цаасан хэлбэрээр санал авч нэгтгэсэн байна. Аудитын явцад хийсэн судалгаагаар сумдын хэмжээнд нийт 10,158 иргэн ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санал өгчээ.

Сумын Засаг дарга ажлын хэсгийн гаргасан эрэмбэлсэн жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д оруулж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ажлыг

батлуулсан боловч Баянцагаан, Баян-Өнжүүл сумын Засаг дарга журамд заасны дагуу ажлын хэсэг байгуулаагүй, багийн ИНХ-аас гарсан саналыг эрэмбэлж жагсаалт гаргах ажил хийгдээгүй байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 6 дугаар зүйлд заасныг зөрчсөн байна. Бусад сумдын хувьд багийн түвшинд иргэдийн санал авах нэгтгэх, эрэмбэлсэн жагсаалт гаргах ажил журамд заасны дагуу хэрэгжиж байгаа боловч зарим сумд иргэдээс санал аваагүй ажлыг эрэмбэлсэн жагсаалтад оруулж батлах, иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг ИТХ-аар батлах зэрэг зөрчил гарчээ. Тухайлбал:

- Эрдэнэ суманд машин угаалга, засварын газар барих 89.3 сая төгрөгийн ажил багийн иргэдээс санал аваагүй байхад эрэмбэлсэн жагсаалтад оруулан ИТХ-аар батлуулсан байна.
- Баянжаргалан сумын ОНХС-ийн хөрөнгөөр мод хашаажуулах ажил, сумын төвийн худаг, халуун ус засвар зэрэг 259.0 сая төгрөгийн, Баянхангай сум ЕБС-ийн кабинет тохижилт, дундаж хурд хэмжигч, газар ашиглалтын судалгаа зэрэг нийт 81.5 сая төгрөгийн ажлыг иргэдээс санал аваагүй байхад сумын ИТХ-аар батлуулсан байна.

Аймгийн ОНХС нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.5-д “урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Сумд нь орон нутгийн хөгжлийн сангийн журмын 6 дугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөхдөө хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон бусад шалгуураар санал асуулга авчээ.

Аймаг, сумын ИТХ-аас нийт 569 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил хэрэгжүүлэхээр 37,513.8 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөж баталсан байна. Аймгийн ОНХС-аас 71 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад 11,039.7 сая төгрөгийн санхүүжилт, 27 сумын ОНХС-аас 388 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад 22,811.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт №4: Аймаг, сумын ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

/мян.төг/

№	ОНХС-ийн нэр	Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээ	
		Тоо	Мөнгөн дүн
1	27 сумын дүн	498	26,474,144.5
2	Төв аймаг ОНХС	71	11,039,662.5
	Нийт дүн	569	37,513,807.0

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын “2024 оны төсөв батлах тухай” тогтоолууд

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 03 дугаар тогтоолоор 12,030.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 71 төсөл, арга хэмжээнд 11,039.6 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг тодотгон баталжээ.

Аймгийн ОНХС-д батлагдсан төсөл хөтөлбөрт 362.0 сая төгрөгийн 6 ажил урд онд хэрэгжсэн ажлын үлдэгдэл санхүүжилт, үлдсэн 10,667.6 сая төгрөгийн 65 ажил нь шинээр хэрэгжих ажлууд байна. Эдгээрээс 5,702.9 сая төгрөгийн 44 ажил нь 26 суманд буюу эрх шилжих ажлууд батлагдсан нь аймгийн ОНХС-ийн нийт санхүүжилтийн 53,5 хувь буюу тооны хувьд 67,7 хувийг эзэлж байна. Тухайлбал: ТАХ-ийг орон сууцаар хангахад 700.0 сая төгрөг баталж 7 суманд тус бүр 100.0 сая төгрөг, гэр хорооллын айл өрх, үйлчилгээний

байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбоход 720.0 сая төгрөг баталж, 9 суманд тус бүр 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг сумдад эрх шилжүүлсэн байна.

Сумдад хэрэгжих ажлуудаас гадна зарим төсөл, хөтөлбөр, аймгийн төвийн барилга байгууламжийн засвар, тоног төхөөрөмж, тохижилтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Аймгийн төвийн зарим төрийн байгууллагын 15 засвар, тохижилтод 1,441.8 сая төгрөг,
- Шинэ хөдөө төсөлд 450.0 сая төгрөг, Цахим Төв аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 100.0 сая төгрөг, "Хүүхэд бүрд сүү" хөтөлбөрт 400.0 сая төгрөг, Хүүхдийн автобус хөтөлбөр /Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Эрдэнэсант, Заамар, Эрдэнэ, Баянхангай/-т 460.0 сая төгрөг, Хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын төсөл 400.0 сая төгрөг, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 300.0 сая төгрөг, Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнсний ногооны агуулах, ложистикийн цогцолбор байгуулах орон нутгийн оролцоонд 500.0 сая төгрөг, Баг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 100.0 сая төгрөг, Багш бүрд компьютер төсөлд 104.0 сая төгрөг, бүгд 2,814.1 сая төгрөгийг 14 төсөл, хөтөлбөрт,
- Зураг, төсөв боловсруулах 3 зөвлөх үйлчилгээнд 280.8 сая төгрөг,
- Нийтийн тээвэр, шуудан зэрэг үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх 3 зардалд 194.9 сая төгрөг,
- Тоног төхөөрөмж худалдан авах 5 ажилд 243.1 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөсөн байна.

Аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан 4,964.7 сая төгрөгийн санхүүжилтийн дийлэнх хувь буюу 56,7 хувь нь төсөл, хөтөлбөрт зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Аймгаас сумдад эрх шилжиж хэрэгжсэн 5,702.9 сая төгрөгийн 44 ажил, аймгийн төвийн зарим төрийн байгууллагын засвар, тохижилтын 15 ажилд 1,441.8 сая төгрөг, нийт 7,144.7 сая төгрөгийн 59 ажил зураг төсөв нь хийгдсэн байна. Энэ нь нийт төсвийн 64,7 хувийг эзэлж байна. Харин шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 2,814.1 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрүүд нь бараа, тоног төхөөрөмж худалдан авах зориулалттай бөгөөд тоног, төхөөрөмж худалдан авалтад нийт 3,057.2 сая төгрөг зарцуулахаар батлагдсан нь аймгийн ОНХС-ийн нийт төсвийн 27,7 хувийг эзэлж байна.

Сумдын ОНХС-аас хэрэгжихээр батлагдсан 26,474.1 сая төгрөгийн 498 төсөл, арга хэмжээний дийлэнх хувь нь зураг, төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй хэрэгжсэн байна. Үүнд:

- Мөнгөнморьт сум мал угаалгын ванн, эрүүл мэндийн төвийн авто гражийн өргөтгөл барих, хүүхдийн цэцэрлэгийн гадна авто зогсоол байгуулах, дунд сургуулийн хичээлийн хуучин модон цонхыг вакум цонхоор сольж засварлах, голын гүүр шинээр барих, бэлчээрийн хуучин худгийн засвар, мотор шинэчлэн засварлах нийт 135.5 сая төгрөгийн ажлууд,
- Цээл сум 13.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3-н малын худаг засварлах ажил, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Майхан багийн төвийн тохижилтын ажил, 15.9 сая төгрөгийн мал угаалгын ванн тохижуулах ажил, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бор хужирын голд гүүр тавих 48.9 сая төгрөгийн ажлууд,
- Эрдэнэ сум 114.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажил,
- Эрдэнэсант 8.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3-н бэлчээрийн худаг гаргах ажил,
- Баянчандмань сум хуц ухнын өвөлжөө барих 24.5 сая төгрөг, Замт багийн 2, 4-р хорооны зам засвар /хурд сааруулагч, ус зайлуулах хоолой/ 294.4 сая төгрөг, нийт 318.9 сая төгрөгийн 2 ажил,
- Борнуур сумын ИТХ-ын тогтоолоор 495.0 сая төгрөгийн 15 ажил баталснаас 50.0 сая төгрөгийн "наадмын талбайн засвар, гэрэлтүүлэг"-ийн ажлаас бусад 445.0 сая төгрөгийн 9 ажлууд зураг, төсөвгүй батлагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно. Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй", 3.2.2.2-т "барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх", 3.2.3.4-д "тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх" гэсэн заалтууд зөрчигджээ.

Сумд нь төсөл, арга хэмжээ төлөвлөхдөө 20.0 сая төгрөгөөс доош ажилд хяналтын төсөв хийлгэдэггүй, өөрсдийн багцаа үнээр бодит биш үнэлдэг, ижил төстэй ажлуудыг хувааж шууд худалдан авах аргаар олон салгаж баталсан зөрчлүүд гаргажээ. Тухайлбал: Баянцагаан, Баян-Өнжүүл, Мөнгөнморьт, Өндөрширээт, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант сумдууд 20 сая төгрөгөөс доош ажлууддаа зураг төсөв хийлгээгүй, Баянцагаан сумын ИТХ төсвийг хувааж шууд худалдан авах төсвөөр баталсан байна.

Сумдын хувьд хууль, журамд заагдаагүй зарим чиг үүргийг ОНХС-аар хэрэгжүүлэхээр баталжээ. Тухайлбал: Баянцогт сум ЗДТГ-ын засварт 99.9 сая төгрөг, Дэлгэрхаан сум ЗДТГ-ын шинэ баригдсан барилгын дэд бүтцийн санхүүжилтэд 338.4 сая төгрөг баталжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй ...", 60.4-т "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", 4.4-т "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд: 4.4.1-д "Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи", 4.4.2-т "Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ", 4.4.3-д "Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах" гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга зам, зорилго зорилтыг бүрэн тодорхойлоогүй, тооцоо судалгаа дутуу хийгдснээс тоног төхөөрөмж худалдан авахаас өөр ажил хийгдээгүй, үр дүнгүй байна.

Сумд нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах, гэрээ байгуулсан өдрөө буюу ажлын гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилтийн 40-100 хувийг урьдчилгаагаар олгосон байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжихээр батлагдсан нийт 37,513.8 сая төгрөг 569 төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын 13,269.9 сая төгрөгийн 62 ажил нээлттэй тендер

шалгаруулалт, 8,633.2 сая төгрөгийн 141 ажил харьцуулалтын аргаар, 5,997.7 сая төгрөгийн 245 ажилд шууд худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт №5: Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгийн ХАА-ны судалгаа

/мян.төг/

№	ОНХС-ийн нэр	ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээ		Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан					
		Тоо	Дүн	Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	27 сумын дүн	498	26,474,144.5	41	9,043,452.3	103	5,230,735.20	238	5,243,063.0
2	Төв аймаг ОНХС	71	11,039,662.5	21	4,253,406.1	38	3,402,475.90	7	754,660.0
	Нийт дүн	569	37,513,807.0	62	13,296,858.4	141	8,633,211.10	245	5,997,723.0

Эх сурвалж: Аудитын ажлын баримтууд

Сумдад хөрөнгө оруулалтын батлагдсан зураг төсөвгүй ажлыг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтоор, батлагдсан санхүүжилтийг хувааж шууд гэрээ байгуулжээ. Үүнд:

- Алтанбулаг сум халуун усны тохижилтын ажлын батлагдсан төсөв 12.6 сая төгрөг байхад гэрээг 15.0 сая төгрөгөөр байгуулсан,
- Борнуур сум Мандал багийг камержуулах 50.0 сая төгрөгийн ажилд 20.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан,
- Баянхангай сум нэгдсэн хогийн цэг овоолго хийх, булшлах 30.0 сая төгрөгийн ажлыг 2 хувааж шууд гэрээ байгуулсан.
- Эрдэнэ суманд 40.0 сая төгрөгийн ажил, Эрдэнэсант суманд 34.8 сая төгрөгийн ажлуудыг 2 хувааж шууд худалдан авалт хийсэн,
- Мөнгөнморьт сум дунд сургуулийн хичээлийн хуучин модон цонхыг вакум цонхоор сольж засварлах 33.0 сая төгрөгийн ажлыг 19.7 сая төгрөг, 13.3 сая төгрөгөөр 2 хувааж шууд худалдан авалт хийсэн,
- Эрдэнэсант 3-р багийн төвийн барилгын засварын 34.8 сая төгрөгийн ажлыг 19.9 сая төгрөг, 14.9 сая төгрөгөөр 2 хувааж шууд худалдан авсан,
- Баянцагаан сум наадмын асарыг тохижуулах засварлах 19.8 сая төгрөг, арьс шир нэхий боловсруулах цех байгуулах 9.0 сая төгрөг, ёслол хүндэтгэлийн өргөө тохижилт 20.0 сая төгрөг, ЕБС-д бие засах газартай болох /5,8/-р багийн төвийн 00-ийн сейптинг, халуун ус, 00 руу ус татах төхөөрөмж /12,2/ 15.6 сая төгрөг, сумын төвийн машин зам засвар, тэмдэг тэмдэглэгээ 7.2 сая төгрөг, нийт 71.7 сая төгрөгийн ажлын захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй шууд гэрээ байгуулсан,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.8.31-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхгүй", 4.8.32-т "Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх,

батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх” гэсэн заалтууд зөрчигджээ.

Мөн Жаргалант, Баянцагаан, Баян-Өнжүүл, Лүн сумд нь худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны нарийн бичиг худалдан авах ажиллагааны баримт бичгийн стандарт, дэс дараалал, тавигдах шаардлагуудыг журмын дагуу хөтөлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Жаргалант сум Баянбулаг багийн цэцэрлэгийн дээврийн засвар, 4-р багийн гүүр засвар, нийтийн биеийн тамирын талбай /Загдал багт/, бэлчээрийн худаг гаргах, гэрэлт цамхаг хийх ажлуудад хяналтын төсөв хийж батлуулахгүйгээр тоон мэдээлэлгүй техникийн тодорхойлолтоор худалдан авах ажиллагааг зарлаж гэрээ байгуулсан,
- Баян-Өнжүүл сум худалдан авах ажиллагааг зарлахдаа захиалагчийн хяналтын батлагдсан төсөвгүй, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үнийн судалгаагүй тоо ширхэгээр хийсэн байна. Тухайлбал: Залуучуудын хөгжлийн төв дотор засвар 39.8 сая төгрөг, залуучуудын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж 59.8 сая төгрөг, Төрийн албан хаагчдийн байрны гадна талбайн тохижилт 29.0 сая төгрөг, Ёслол хүндэтгэлийн өргөө барих 121.5 сая төгрөг, Соёлын төвийн тохижилт 24.6 сая төгрөг, Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт 29.0 сая төгрөг, нийт 303.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн,
- Баян-Өнжүүл сум спорт чийрэгжүүлэлт, Залуучуудын хөгжлийн төвийг тохижуулах хяналтын төсөвгүй ажлыг дотор нь 2 хувааж 39.8 сая төгрөгөнд засварын ажил, 59.8 сая төгрөгөөр фитнес тоног төхөөрөмж худалдан авч тус тусад нь худалдан авах ажиллагаа зарласан байна. Нэмэлт ажлын төсвийг тодотголоор оруулж 20.0 сая төгрөг батлуулан техник, хэрэгсэл худалдан авч засвар хийсэн компаниар дамжуулан шууд худалдан авалтаар гэрээ байгуулалгүй, нийт 119.7 сая төгрөгийг зарцуулсан,
- Баян-Өнжүүл сум төрийн албан хаагчдын орон сууц 171.3 сая төгрөгийн хяналтын төсөвтэй ажилд 00 хийлгэх ажлын төсвийг ямар нэгэн тодруулга, нэмэлт ажлын гэрээгүйгээр шууд нэмж гүйцэтгэгчтэй 199.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан,
- Лүн сумын төвийн төв талбайн тохижилтын ажилд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 181.0 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан. Тус ажлын худалдан авах ажиллагааг зарлахдаа хяналтын төсвийг 111.5 сая төгрөгөөр хийж зарласан байхад гүйцэтгэгчтэй хяналтын төсвөөс хэтрүүлэн 175.4 сая төгрөг буюу 58.8 сая төгрөгөөр илүү гэрээ байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална, 11.2-т “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана, 52 дугаар зүйлийн 52.1-д “Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ” гэснийг зөрчсөн байна.

ОНХС-аас хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажилд санхүүжилт олгохдоо төсвийг өндрөөр хийж илүү санхүүжилт олгосон, ажлын гүйцэтгэл гараагүй ажил хийгдээгүй байхад 40-100 хувийн урьдчилгаа санхүүжилт олгох, захиалагч, зохиогчийн хяналтын зардлыг суутган тооцолгүй гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгосон зөрчлүүд гарлаа. Тухайлбал:

- ✓ Зуунмод суманд 2 ажлын хяналтын төсвийг өндрөөр хийж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, санхүүжилт олгосон байна. Аудитын явцад хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь очиж ажлын бодит гүйцэтгэлийг шалгахад дараах зөрчлүүд гарлаа. Үүнд:
 - "Баянхошуу багийн явган зам, гэрэлтүүлэг"-ийн ажлыг захиалагч Зуунмод сумын ЗДТГ нэг толгойтой, 5 метрийн өндөртэй 1 гэрлийн үнийг 2 дахин илүү үнээр буюу 2.0 сая төгрөгөөр төлөвлөж, "Азиякомплект монтаж" ХХК-тай 48.9 сая төгрөгийн гэрээ байгуулсны 10.0 сая төгрөг нь 5 гэрэл хийх ажил байна. Сумын ЗДТГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 92 дугаартай актад ажил хүлээн авсан комисс 10 ширхэг гэрэл хүлээн авснаар акт үйлдсэн байна. Гүйцэтгэгч компани захиалагчтай байгуулсан гэрээний дагуу 5 ширхэг гэрлийг тус бүрийг 2.0 сая төгрөгөөр тооцож гүйцэтгэлийг гаргажээ. Ажлын бодит гүйцэтгэлээр 5 ширхэг гэрэл хүлээлгэн өгсөн бөгөөд 10 гэрлийн үнэ 10.0 сая төгрөгөөр 5 гэрэл хийж, 5.0 сая төгрөг илүү санхүүжүүлсэн,
 - "Төв гэрэл" ХХК нь "Баянхошуу багийн гудамжны гэрэлтүүлэг"-ийн нэг толгойтой, 6 метрийн өндөртэй 1 гэрлийн үнийг 2.0 сая төгрөгөөр тооцож гэрээ байгуулсан нь бусад ижил төстэй гэрэлтүүлгийн ажлын төсвөөс өндөр үнэтэй төсөвлөсөн байна. Барилга, байгууламжийн ажлын норм, нормативын дагуу төсвийг тооцоогүйгээс төсөвт өртөг бодит бус, өндөр тооцогдож, гэрээ байгуулсан байна. Иймд бусад гудамжны гэрэлтүүлгийг ажлын жишиг үнэ 1.65 сая төгрөгөөр тооцоход 17 гэрэлтүүлгийн ажилд 6.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгожээ.
- ✓ Баянхангай сум нэгдсэн хогийн цэг овоолго хийх ажлыг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 19.0 сая төгрөгөөр 2024.10.10-2024.10.17-ны өдөр гүйцэтгэх, хогийн цэгийг булшлах 11.0 сая төгрөгийн ажлыг мөн 2024.10.10-2024.10.17-ны өдөр гүйцэтгэх гэрээг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр буюу ажил эхэлсний дараа байгуулсан хугацааны хувьд зөрүүтэй, тухайн ажлыг иргэн Миеэсүрэнгийн ажил хүлээлцсэн актаар хүлээн авч, санхүүжилтийг олгосон нь өмнө гүйцэтгэсэн ажил буюу 1 ажилд давхардуулж гэрээ байгуулан санхүүжүүлэн 11.0 сая төгрөг илүү санхүүжүүлсэн,
- ✓ Баянцагаан сум ЕБСургуулийн цахилгааны төлбөр болох 0.5 сая төгрөгийг сумын 100 жилийн хандиваас, сумын Хоршоо хөгжүүлэх сангийн программ сунгалтын төлбөр 0.2 сая төгрөгийг төлж зориулалт бус зарцуулсан.
- ✓ Лүн сум малын тоо толгойн албан татварын орлогоор хийж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд нийт 70.0 сая төгрөгийн 3 ажил төлөвлөсөн боловч малын тоо толгойн албан татварын орлого бүрэн төвлөрүүлээгүй 10.0 сая төгрөгийг төвлөрүүлэн, 39.5 сая төгрөгийг зарцуулж, 29.5 сая төгрөгийг илүү зарцуулсан.
- ✓ Лүн сум санхүүгийн программ архивлах зардалд 0.2 сая төгрөг, сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд 44.7 сая төгрөг төсөвлөгдсөн боловч хэрэгжээгүй төсөл арга хэмжээнээс шууд худалдан авалтаар цэцгийн үр 1.0 сая төгрөг зарцуулан гэрээ, хийсэн ажлын тайлан байхгүй тус тус зориулалт бус зарцуулсан.
- ✓ Лүн сумын төвийн Төв талбайн тохижилтын ажлыг хяналтын төсвөөс 58.8 сая төгрөгөөр хэтрүүлэн 175.4 сая төгрөгөөр гэрээ байгуулж, санхүүжүүлсэн. Уг ажлыг гүйцэтгэхдээ зураг төсөвт тусгагдсан хүүхдийн тоглоомын иж бүрдэл, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, саравч, ногоон байгууламж, хуучин теннисний талбайг засварлах гэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээгүй орхисон мөн хөшөө хийх болон сагсны талбайг засварлах ажлуудыг дутуу хийсэн байна.

Лүн сумын төв талбайн тохижилт- 175.4 сая төгрөг



Зургийн тайлбар: Гүйцэтгэгч Цахирт ану ХХК төсөвт тусгагдсан зарим ажлыг дутуу хийсэн.

- ✓ Баян-Өнжүүл сум Залуучуудын хөгжлийн төвийн нэмэлт ажлын 20.0 сая төгрөгөнд гэрээ байгуулахгүйгээр шууд худалдан авалтаар фитнесийн тоног төхөөрөмж хэрэгслүүд, гадна хашааны оронд адууны хашааг 2.4 сая төгрөгөөр, үүдний тек 4ш авахаас 3ш нь ирээгүй 1.5 сая төгрөгийг компанид төлсөн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.32-т “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх”, 5 дугаар зүйлийн 5.3.6-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэсэн заалтууд зөрчигдсөн.

Ихэнх сумдууд хөрөнгө оруулалтын ажилд гэрээ байгуулсан өдөр буюу ажил нь хийгдээгүй, ажлын гүйцэтгэл гараагүй байхад 70-100 хувийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Алтанбулаг сум халуун ус засварлах ажилд 70 хувь, тоглоомын талбай байгуулах ажилд 70 хувь, морины шүтээн байгуулах ажилд 70 хувь, цэцэрлэгийн гадна талбай тохижуулах ажилд 70 хувь, худаг гаргах ажилд 50 хувь, явган зам хийх ажилд 40 хувь, залуус цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд 40 хувийн нийт 108.4 сая төгрөг,
- Архуст сум лед дэлгэц худалдан авахад 70 хувь, Өндөрлөг хашаажуулах ажилд 80 хувь, худаг засварын ажилд 80 хувь, эко 00 хийх ажилд 50 хувь, цөм сүрэг худалдан авахад 70 хувь, нийтийн эзэмшлийн камер суурилуулах ажилд 70 хувийн нийт 76.7 сая төгрөг,
- Батсүмбэр сум наадмын талбай засварлах ажилд 50 хувь, Мандал багт нийтийн эзэмшлийн талбай засварын ажилд 50 хувь, 2,3 дугаар багт худаг гаргах ажилд 50 хувийн нийт 151.1 сая төгрөг,

- Баяндэлгэр сум иргэний танхим засварын ажил, худаг засварын ажлын төсөв, гүйцэтгэл, хүлээж авсан акт, хурлын тэмдэглэл, тендерийн баримт материал дутуу, зураг төсөв хийх ажлын хүлээж авсан акт байхгүй байхад 61.0 сая төгрөг,
- Баянжаргалан сум халуун ус засварлах ажилд 70 хувь, дотуур байрны тоног төхөөрөмж худалдан авах ажилд 80 хувь, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний ажилд 70 хувь, эко 00 хийх ажилд 70 хувь, сургуулийн засварт 80 хувь, гамшигийн хашааны ажилд 70 хувь, зураг төсвийн ажилд 70 хувь гэх мэт ажилд 863.6 сая төгрөг,
- Мөнгөнморьт сум мал угаалгын ванн, эрүүл мэндийн төвийн автогражийн өргөтгөл барих, дунд сургуулийн хичээлийн хуучин модон цонхыг вакум цонхоор сольж засварлах, хүүхдийн цэцэрлэгийн гадна авто зогсоол байгуулах ажлуудад 70 хувь, гүүр засварлах, тоглоомын талбай шинэчлэн засварлах, гэрэлт гудамж байгуулах ажлуудад 80 хувь, бэлчээрийн хуучин худгийн засвар, мотор шинэчлэн засварлах ажилд 100 хувь, нийт 204.5 сая төгрөг,
- Сүмбэр сум мал угаалга ванн болон ариутгалын багж хэрэгсэлд 63 хувь, төв зам дагуух гэрэлтүүлэг, орон нутгийн зам засварын ажилд 80 хувь, нийт 204.5 сая төгрөг,
- Цээл сум цэцэрлэгийн хүүхдийн тоглоом шинэчлэх, багийн тохижилтийн ажилд 80 хувь, мал угаалгын ванн засварлах, малын худагт урсгал засвар хийх, гар худаг сэргээн засварлах 2 ажил, голд гүүр тавих ажлуудад 100 хувь, нийт 86.8 сая төгрөг,
- Эрдэнэ сум цэнгэдэх хүрээлэнгийн засварын ажилд 83 хувь, зөөврийн эко нойл, 4 багийн төвийн засвар, сумын цэнгэлдэх хүрээлэнгийн асфальтан тойрог замын ажлуудад 70 хувь, худаг гаргахад 60 хувь, наадмын талбайн зүлэгжүүлэлтийн ажилд 100 хувь, нийт 271.9 сая төгрөг,
- Эрдэнэсант сум халуун ус, угаалгын төвийн барилгын ажил, гар худаг сэргээн засварлах 2 ажил, багийн төвийн байрны засварын ажлуудад 50 хувь, гэр хорооллын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажилд 80 хувь, бэлчээрийн худаг гаргах 3 ажилд 100 хувь, нийт 220.7 сая төгрөг,
- Баянхангай сум Хог хаягдлын тоног төхөөрөмж, сургалтын 20.0 сая төгрөг, камержуулалт хийх 4.0 сая төгрөгийн ажлуудад урьдчилгаа санхүүжилтэд 80.0 хувь буюу 19.2 сая төгрөг,
- Баянчандмань сум "Хуц ухны өвөлжөө барих" 24.2 сая төгрөгийн ажилд 80 хувь буюу 19.4 сая төгрөг олгожээ.
- Жаргалант сум цэцэрлэгийн дээврийн засвар 60 хувь, явган хүний зам 80 хувь, 4-р багийн гүүр засвар 80 хувь, нийтийн биеийн тамирын талбай /Загдал багт/ 50 хувь, сургуулийн гадна талбайн тохижилт, дээвэр засвар гэрээ байгуулсан өдөр 70 хувь, бэлчээрийн худаг гаргах 40 хувь, Хог ангилан ялгах хашаа /Баянбулаг багт/ 80 хувь, гэрэлт цамхаг хийх гэрээ байгуулсан өдөр 80 хувь, бүгд 384.3 сая төгрөг,
- Баянцагаан сум наадмын асар тохижуулах засварлах, ёслол хүндэтгэлийн өргөөний суурь, Арьс шир нэхий боловсруулах цех байгуулах, мал угаах ванн, гэр бүл Хүүхэд залуучуудын өрөө засварлах, тохижуулах, Гүний худаг, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, гүний худгийн цооног, сумын төвд Баяр наадмын асар талбайд стандартын бие засах газартай болох ажил, гэр хорооллын гудамж талбайн замыг янзлах, Баян сумтай холбох хатуу хучилттай замын зураг төсөв хийлгэх ажлуудад 50-100 хувийн урьдчилгаа санхүүжилтад 377.6 сая төгрөг,
- Лүн сум төв талбайн тохижилт, Төмөр-Очирын хөшөөт цогцолборын гэрэлтүүлэг чимэглэлийн ажил, нийтийн эзэмшлийн газарт эко нойл, хогийн сав байршуулах, наадмын талбайн их засвар, Спорт цогцолборын үзэгчдийн суудал, бэлчээрийн худгийн цооног гаргах ажлуудад 40-100 хувийн урьдчилгаа санхүүжилтэд 246.6 сая төгрөгийг олгосон байна.

Зарим сумдууд комиссын актаар хүлээж аваагүй ажлуудад санхүүжилтийг бүрэн олгожээ. Тухайлбал: Дэлгэрхаан сум 104.0 сая төгрөгийн, Баян-Өнжүүл сум 199.3 сая төгрөгийн гэрээтэй ТАХ-ын орон сууцыг ажил хүлээлцэх комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-т "Тендер шалгаруулалтын баримт

бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө", 4.3.3-д "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг энэ журамд зааснаар олгох бөгөөд санхүүжилтийг дараах байдлаар ангилна", 4.3.1.1-д "эхний санхүүжилт", 4.3.1.2-т "дундын буюу явцын санхүүжилт", 4.3.1.3-д "эцсийн буюу бүрэн санхүүжилт", 4.8.12-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно", 4.8.12.1-д "тухайн төсөл, арга хэмжээнд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тус тус тусгасан байх", 4.8.12.2-д "урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар баталсан "Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон даатгалын маяг"-ын дагуу гаргана)", 4.8.13-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна" гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Аймгийн ОНХС болон сумд нь гүйцэтгэгчид санхүүжилт олгохдоо захиалагч, зохиогчийн хяналт, зураг төсвийн үнийг суутган тооцолгүй 36.5 сая төгрөгийг гүйцэтгэгчид илүү санхүүжүүлсэн зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн ОНХС-аас хэрэгжсэн гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох (Жаргалант сум) ажлын гүйцэтгэгч Тэнгэрийн тулгуур барилга ХХК-д 2.1 сая төгрөг, эрүүл мэндийн төвийн их засвар (Аргалант сум)-ын гүйцэтгэгч Тусгал төв ХХК-д 5.5 сая төгрөг, Лүн сумын соёлын төвийн их засварын гүйцэтгэгч Дөрвөнлхагва ХХК-д 4.9 сая төгрөг, бүгд 12.5 сая төгрөгийн захиалагч, зохиогчийн хяналтын зардал,
- Баянжаргалан сум 4 ажилд 3.4 сая төгрөг, Баянчандмань сум "Замт багийн 2,4 дүгээр хорооны зам засвар /хурд сааруулагч, ус зайлуулах хоолой/-ын ажилд 4.2 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал,
- Жаргалант сумын төвд 4-р багийн гүүр засварын ажлыг гүйцэтгэсэн Гэрэлтэй мөнгөн суурь ХХК-д ажлын хөлсийг шилжүүлэхдээ захиалагчийн хяналтын зардал, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал 1.7 сая төгрөгийг төсөвт тусгалгүй зөвхөн магадлашгүй ажлыг тусгаж, илүү санхүүжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх", 4.3.9-д "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, ашиглалтад орсонтой холбогдуулан энэ журмын 4.3.8-д заасан зардлаас зарцуулагдаагүй үлдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Зарим сумд малын тоо толгойн орлогоо дутуу төвлөрүүлж, төвлөрсөн орлогоос хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал:

- Баян-Өнжүүл сум малын тоо толгойн албан татварын орлогоос зарцуулагдах төсөл, арга хэмжээнд Малчдын чуулга уулзалт, сургалт сурталчилгаа явуулах зардлаас аварга малчдад өгөх шагналын зардалд 8.0 сая төгрөгөнд бэлэг дурсгал, шатахууныг зориулалт бусаар зарцуулсан, мөн малын тоо толгойн албан татварын орлого төвлөрүүлээгүй тул ОНХС-аас зарцуулсан зөрчил илэрсэн.

- Баянцагаан сум Малын тоо толгойн албан татварын орлогоор хийж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд нийт 36.2 сая төгрөгийн 6 ажил төлөвлөсөн боловч малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлээгүй 2023 оны үлдэгдэл 1.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 24.6 сая төгрөгийг илүү зарцуулсан зөрчил илэрсэн.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга, хүрэх үр дүн, зорилго, зорилтыг тодорхойлж, тооцоо судалгаа хийгээгүйгээс тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж, тухайн төсөл, хөтөлбөр зорилтот түвшинд хүрээгүй, үр ашиг, үр дүнгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжсэн зарим төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд зорилтот түвшинд хүрээгүй, үр ашиг, үр дүнгүй байна. Тухайлбал:

- Эрдэнэ суманд машин угаалга, засварын газар барих 89.3 сая төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэж зориулалтын дагуу ашиглаагүй, одоогоор машины граш зориулалтаар ашиглаж байгаа нь төлөвлөсөн зорилтод түвшинд хүрээгүй, үр дүнгүй ажил болсон байна.
- Аймгийн ОНХС-аас "Шинэ хөдөө" төсөл хэрэгжүүлэх ажлын Багц-1 Хонь ноослох тоног төхөөрөмжийн иж бүрдэл 2 ширхэгийг 130.7 сая төгрөгөөр худалдан авч Өндөрширээт, Эрдэнэсант сумдад хуваарилсан боловч зориулалтын дагуу ашиглаагүй байна.
- "Хүүхэд бүрд сүү" хөтөлбөрөөр 277.0 сая төгрөгөөр худалдан авсан тоног төхөөрөмжийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт эзэмшүүлж, Эрдэнэ сумын ПТК, Нүүдэлчин агро ферм ХХК-д ашиглуулах гэрээ байгуулсан боловч тухайн 2 газар нь зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Аймгийн Засаг даргын "Тоног төхөөрөмж ашиглуулах тухай" захирамжаар Эрдэнэ сумын ПТК-д 103.2 сая төгрөгийн, Нүүдэлчин агро ферм ХХК-д 146.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглуулахаар шийдвэрлэжээ. Сүү нийлүүлэх тоног төхөөрөмж ашиглуулах гэрээнд "жил бүрийн 9 сарын 1-ээс 6 сарын 1-ний өдөр хүртэл сав баглаа боодол, тээвэрлэлтийн зардлыг оруулж тооцон 1л сүүг 5400 төгрөгөөр Эрдэнэ сумын ПТК аймгийн төвийн 2 сургууль, 7 сумын 6170 хүүхдэд, Баянхангай суманд байршилтай Нүүдэлчин агро ферм ХХК аймгийн төвийн 2 сургууль, 10 сумын 5963 хүүхдэд өдөр бүр өгөх 1 жилийн хугацаатай гэрээг байгуулсан байна. Тоног төхөөрөмж ашиглуулах шийдвэрийг аймгийн Засаг дарга 2024 оны 11 дүгээр сарын 12-нд гаргаж, ашиглагч 2 байгууллага 2024 оны 12 дугаар сарын 25-нд орлогод авчээ. Тухайн 2 газар сүү нийлүүлсэн талаар ямар нэгэн тайлан, тооцоог аймгийн ОНӨГ-т ирүүлээгүй, Нүүдэлчин агро ферм ХХК нь сүү үйлдвэрлэх байрны асуудал шийдэгдээгүй гэдэг шалтгаанаар тоног, төхөөрөмжийг ашиглаагүй сумын төвийн нэг байранд хураасан байдалтай байна. Эрдэнэ сумын ПТК нь сумын ЕБС-ийн 820 сурагч, Нарлаг цэцэрлэгийн 225 хүүхэд, нийт 1045 хүүхдэд 150 гр савлагдсан ариутгасан сүүг 7 хоног бүрийн мягмар, лхагва, пүрэв гаригуудад нийлүүлж эхэлсэн бөгөөд хуваарьт сумдад сүү нийлүүлээгүй байна.

Сүү хөтөлбөр-277.0 сая төгрөг



Зургийн тайлбар: Сүү хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэ сумын ПТК-ийн үйлдвэрлэсэн сүү

Тухайн төслийн хувьд хөдөө орон нутагт 1 сүү 5400 төгрөгөөр, Эрдэнэ сумаас 687 км, Баянхангай сумаас 2176 км газарт өдөр бүр сүү хүргэхээр тооцож гэрээ байгуулсан нь тухайн төслийн хувьд тооцоо судалгаа муутай, үр ашиггүй болохыг харуулж байна.

- Хүүхдийн автобус хөтөлбөр /Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Эрдэнэсант, Заамар, Эрдэнэ, Баянхангай/ сумдад 8 автобус нийлүүлэх худалдан авах ажиллагааг нээлттэй зохион байгуулж, Хаш техник ХХК 460.0 сая төгрөгөөр шалгарч, гэрээ байгуулсан байна. Тус компани нь техникийн тодорхойлолтод заасны дагуу Хятад улсаас 2016 оноос хойш үйлдвэрлэгдсэн, +45 хэмд ашиглах боломжтой, 22-оос дээш зорчигчийн суудалтай автобус тус бүрийг 57.5 сая төгрөгөөр нийлүүлэх саналыг ирүүлж, шалгарчээ. Хүүхдийн автобус хүлээлцэх ажлын хэсгийн тэмдэглэлд "Гаалиар эхэлж орж ирсэн 6 автобусны нэгнийх дугуй хагарсан, нэг нь эвдэрсэн тул үлдсэн 4 автобусыг техникийн үзлэгт оруулахад бүгдийнх нь тормос барихгүй, дотор дулаалга байхгүй, сигнал ажиллахгүй гэх мэт техникийн шаардлага хангаагүй автобуснуудыг гүйцэтгэгчид засвар хийж, янзлаад хүлээлгэж өгөх үүрэг өгсөн байна. Хүүхдийн автобусыг 10-аас дээш жил ашиглах боломжгүй тул 2017 онд үйлдвэрлэгдсэн автобуснууд нь 2027 оноос хойш явах боломжгүй, 3 жил Монгол улсад яваад ашиглах боломжгүй талаар дурдсан байна. Нэмж орж ирсэн 2 автобус нь мөн эвдрэлтэй байсныг засаж янзлах үүрэг өгсний дагуу гүйцэтгэгчээс засвар хийж 8 суманд хүлээлгэн өгсөн байна.

Хүүхдийн автобус хөтөлбөр-460.0 сая төгрөг /гүйцэтгэгч Хаш техник ХХК/



Зургийн тайлбар: Хүүхдийн автобус хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн Хятад автобус

Төсөв мөнгө хүрэлцээгүй гэдэг шалтгаанаар 460.0 сая төгрөгөөр Хятад улсад үйлдвэрлэгдсэн, 2017 оноос хойш 7 жил ашиглагдсан, бага насны хүүхдэд зориулсан жижиг суудалтай, техникийн шаардлага хангаагүй, эвдэрхий автобуснуудыг хүлээн авч ОНХС-ийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулжээ.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 29 дүгээр зүйлд заасан 29.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-т “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.8-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй танилцах, үнэлэх, төсвийн үр ашиг, ач холбогдол, үр дүнг тооцох чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллах, энэ хүрээнд аргачлал, үнэлгээний арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэх”, 2.1.9-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмчийн удирдлага, ашиглалтыг хянах”, 2.2.6-д “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, бүрэн хариуцах”, 2.2.10-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх”, 2.2.13-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналт, ил тод, нээлттэй байдал болон тайлагналтын үйл ажиллагаа, үр ашиг, үр дүнг бүрэн хариуцаж ажиллана”, 3 дугаар зүйлийн 3.2.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй”, 3.2.3.3-д “холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх”, 4 дүгээр зүйлийн 4.10.1.4-т “захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах”, 6.1.6-д “Гэрээний талууд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна” гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 76 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 8,029.2 сая төгрөг зарцуулжээ. Үүнээс иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи чиглэлээр 4,582.4 сая төгрөгийн 35 арга хэмжээ, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 1,681.3 сая төгрөгийн 22 ажил, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 986.9 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ байна. Аймгаас хөдөө орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор ТАХ-ийг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэхэд 700.0 сая төгрөг, гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох ажлыг 9 суманд хэрэгжүүлэхэд 720.0 сая төгрөг баталж зарцуулсан нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөх ажлууд болжээ.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 398 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 17,184.1 сая төгрөг зарцуулжээ. Үүнээс иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи чиглэлээр 2,496.9 сая төгрөгийн 49 арга хэмжээ, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 5,830.4 сая төгрөгийн 79 ажил, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 4,236.4 сая төгрөгийн 118 төсөл, арга хэмжээ байна.

Сум, орон нутагт иргэдээс авсан санал асуулгын дагуу олон жижиг ажил төлөвлөж, төсвийг жижиглэж, худаг ус гаргах, тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тохижуулах зэрэг ажлуудад зарцуулагдаж байна.

2.3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжсэн зарим хөрөнгө зориулалтын дагуу ашиглагдаагүй байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 8 суманд хэрэгжсэн 460.0 сая төгрөгийн хүүхдийн автобуснуудаас Заамар, Эрдэнэ сумд автобусыг зориулалтын дагуу ашиглаж байгаа бөгөөд бусад 6 сумдын хувьд эвдэрсэн, бага насны хүүхдийн зориулалттай жижиг суудалтай, жижиг оврын автобус учраас сургуулийн хүүхэд зөөх боломжгүй, хүйтний улиралд халаалт байхгүй, байнга эвдрэл гардаг, жолоочгүй зэргээс шалтгаалан ашиглалтгүй байна.
- Хүүхдийн сүү хөтөлбөрийн хүрээнд худалдаж авсан тоног төхөөрөмжийн Нүүдэлчин агро фермд ашиглуулахаар өгсөн тоног төхөөрөмжийн байрны асуудал шийдвэрлэгдээгүй гэдэг шалтгаанаар ашиглалтгүй байна. Мөн тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ашиглалтын гэрээ байгуулсан Эрдэнэ сумын ПТК нь зөвхөн Эрдэнэ сумын хүүхдүүдэд сүү нийлүүлж, бусад гэрээ байгуулсан 7 сумын хүүхдүүд сүү нийлүүлээгүй, тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй байна.
- Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлсэн 130.7 сая төгрөгийн хонь ноослох тоног төхөөрөмжийг 2 суманд хүлээлгэж өгсөн боловч мөн ашиглалтгүй хадгалагдаж байна.
- Баян-Өнжүүл сум соёлын төвийн өрөөний тохижилтын ажлыг хэрэгжүүлэхдээ караокены зориулалтаар тохижуулж, 24.6 сая төгрөгөөр өрөөний засварын ажил, караокены тоног төхөөрөмж худалдан авч, өнөөдрийн байдлаар ашиглалтгүй байна.

Баян-Өнжүүл сум соёлын төвийн өрөөний тохижилт-119.7 сая төгрөг



Зургийн тайлбар: Батлагдсан ажлыг өөрчилж караокены зориулалтаар засвар хийж, тохижуулсан.

Хүүхдийн автобус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн ашиглалтгүй байгаа 6 автобус нь сургуулийн хашаанд ил зогсоолд тавигдснаас бусад хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагч хяналт тавьдаг боловч зөрчил дутагдлыг арилгаагүй байна.

ОНХС-аас хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан бөгөөд захиалагчийн зүгээс хяналт тавьдаг боловч зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасны дагуу Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, ОНХС-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна. Шалгалтыг 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны холбогдох баримтад тулгуурлан шалгаж үнэлэлт дүгнэлт өгснөөс гадна дараах чиглэлээр тодотгож хийсэн байна. Үүнд:

- Төсвөөс олгогдсон санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалт, үр ашиг
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн тайлан мэдээ гаргалтын байдал
- Худалдан авах үйл ажиллагаа, тендер зохион байгуулалт
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ашиглалт, хамгаалалт, орлогод авсан байдал

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг дагаж мөрдөж буй эсэхийг тус тус хамруулан шалгасан байна. Хяналт шалгалтаар нийт 248.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж акт, албан шаардлага өгөгдсөн байна.

Харин сумдын ИТХ-аас хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудад төдийлөн хяналт тавьж ажиллаагүй байна.

ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж ажилласан боловч зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-аас хэрэгжсэн 460.0 сая төгрөгийн хүүхдийн автобус хөтөлбөрийг хүлээж авсан ажлын хэсэг, тухай автобуснууд эвдрэлтэй, техникийн шаардлагуудыг хангахгүй гэдэг техникийн үзлэгээр гарсан боловч хүлээж авсан,
- Лүн сумын төв талбайн тохижилтын ажил зураг, төсвийн дагуу хийгдээгүй байхад ажлын хэсэг хүлээж авсан,

ОНХС-ийн хөрөнгийг захиалагчийн зүгээс ямар нэгэн хяналтгүй зарцуулсан байна.

Үүнд:

- Баян-Өнжүүл сум хүүхдийн тоглоомын талбайн тохижуулалт 29.0 сая төгрөг, сумын онцгой комиссын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл 1.1 сая төгрөг, спорт чийрэгжүүлэлт, залуучуудын хөгжлийн төв нэмэлт санхүүжилт 20.0 сая төгрөг, төрийн албан хаагчдын байрны гадна талбайн тохижуулалт 29.0 сая төгрөг, ёслол, хүндэтгэлийн өргөө барих /нэмэлт санхүүжилт/ 20.0 сая төгрөг, цэцэрлэгийн тоног төхөөрөмж 5.0 сая төгрөг, сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх /өвс, будаа/ 19.5 сая төгрөг тус бүр ажил хүлээлцсэн акт, зурган тайлан байхгүй, хөрөнгийн бүртгэлд орлогод авсан баримтгүй,
- Баянцагаан сумын 100 жилийн ойд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас цугларсан хандивыг ямар нэг хяналтгүй, Засаг даргын захирамжаар төсөв хийж батлахгүйгээр, үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна. Тухайлбал: Зөвхөн хоол хүнсэнд 44.6 сая төгрөг зарцуулснаас Тэрх буянт ХХК-иас 14.4 сая төгрөгийн хуушуур худалдан авсан. Мөн НИК-иас 12.0 сая төгрөгийн шатахууныг бэлэн талоноор авч зарцуулсан, багуудын гар худгийн засварын ажлын төсөв 10.0 сая төгрөгийг шууд худалдан авалтаар багийн 10 малчинд гэрээ байгуулан 9.2 сая төгрөгийг иргэдэд шилжүүлсэн,
- Баян-Өнжүүл сум соёлын төвийн өрөөний тохижилтын ажлыг зориулалтыг өөрчилж караокений зориулалтаар ашиглалтад оруулсан зэрэг зөрчлүүд гарлаа.

Өмнөх аудитаар 124.2 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 4,143.3 сая төгрөгийн 14 албан шаардлага, 36,830.9 сая төгрөгийн 4 зөвлөмж, нийт 41,098.4 сая төгрөгийн зөрчлийг

арилгах 63 акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн байна. Жилийн эцсийн статистик мэдээгээр хэрэгжилт 100 хувийн биелэлттэй гарсан байна.

ОНХС-ийн өмнөх тайлангаар:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 7 дугаар зүйлийн 7.5-д заасан урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байх,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулж ажиллах,

Зуунмод сумын захирагч Ч.Сарангэрэлд:

- ✓ Малын тоо толгойн албан татвараар орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт төлөвлөж, холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллах гэсэн зөвлөмжүүд өгөгдсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагууд албан бичгээр ирүүлсэн бөгөөд аудитын явцад бодит хэрэгжилтийг шалгахад зөвлөмж үр дүнтэй хэрэгжсэн байна. Тухайлбал: Аймгийн ОНХС-д урд онуудад урьдчилгаа санхүүжилт өгөх, удирдлага мэдээллийн системд мэдээллийг огт оруулдаггүй байсан зэрэг зөрчлүүд арилж, Зуунмод сум малын тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт төлөвлөсөн байна.

3.2. Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн цахим системд хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг дутуу мэдээлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлангаар сумын төсвийн дансанд төвлөрсөн 357.4 сая төгрөгийн малын тоо толгойн татварын орлогыг ОНХС-д төвлөрүүлээгүй, авлагаар бүртгээгүй байсанд залруулга хийлгэж, тайлагнуулсан. Гүйцэтгэлийн аудитаар тухайн орлогыг санд төвлөрүүлэх албан шаардлага бичигдлээ.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй, зарим тоног төхөөрөмж тоо хэмжээ үнийн хувьд зөрүүтэй байна. Аудитаар нийт 1,452.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-аас хэрэгжсэн ерөнхий боловсролын сургуульд физикийн туршилтад хичээлийн иж бүрдэл 14 суманд нийлүүлэх тус бүр нь 2.0 сая төгрөгийн үнэтэй 70 ширхэг тоног, төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй,
- Хүүхдийн автобус хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан 345.0 сая төгрөгийн 6 автобусыг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Шинэ хөдөө төсөл хэрэгжүүлэх ажлын Багц-4 үүлдрийн бухны зохиомол хээлтүүлгийн ажил нь сайн үүлдрийн 7 бух худалдаж авахад санхүүжилт олгосон гэсэн боловч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ болон бухыг өгсөн малчинтай байгуулсан гэрээ байхгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Архуст сум модны нүх ухагч худалдан авах зардалд 3.0 сая төгрөг, худаг гаргах ажилд 18.0 сая төгрөг, гэрлийн шугам татах ажилд 8.0 сая төгрөг гэх мэт гэрээт ажлыг комиссын актаар хүлээж аваагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Алтанбулаг сум халуун усны тохижилтын ажилд 10.2 сая төгрөг, эрчим хүч татах ажилд 52.9 сая төгрөг, эрчим хүчний зураг төсөв хийлгэх ажилд 8.0 сая төгрөг, морины шүтээн хийх ажилд 14.0 сая төгрөг, явган зам хийх ажилд 40.3 сая төгрөгийг тус тус зарцуулж, гэрээт ажлыг комиссын актаар хүлээж аваагүй, данс бүртгэлд тусгаагүй байна.

- Баянжаргалан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн гамшгийн хашаа барих 49.5 сая төгрөгийн ажлыг ЗДТГ-т орлого авахдаа 45.0 сая төгрөгөөр орлого авч дутуу орлогодсон гэх мэт зөрчлүүд гарлаа.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлн 5.1.5 “Хариуцлагатай байх”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 2.2.6-д “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, бүрэн хариуцах”, 2.1.9-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмчийн удирдлага, ашиглалтыг хянах”, 2.2.10-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх”, 2.2.13-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналт, ил тод, нээлттэй байдал болон тайлагналтын үйл ажиллагаа, үр ашиг, үр дүнг бүрэн хариуцаж ажиллана”, 3.2.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй”, 3.2.3.3-д “холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх”, 5.5.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ” гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн санд сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний батлагдсан төлөвлөгөө, худалдан авалт, гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг оруулахаар журамд заасан. Гэвч зарим сумд мэдээллийг огт оруулаагүй, дутуу оруулсан зэрэг зөрчлүүд гарлаа. Тухайлбал: Алтанбулаг сум 27 төсөл, арга хэмжээг дутуу, Аргалант сум 5 төсөл, арга хэмжээг бүрэн, Архуст сум 4 төсөл, арга хэмжээг бүрэн, 16 төсөл, арга хэмжээг дутуу, Баян сум 10 төсөл, арга хэмжээг огт оруулаагүй, Баяндэлгэр сум 13 төсөл, арга хэмжээг огт оруулаагүй, Баянжаргалан сум 9 төсөл, арга хэмжээг бүрэн, 21 төсөл, арга хэмжээг огт оруулаагүй, Батсүмбэр сум 8 төсөл арга хэмжээг бүрэн, 1 төсөл, арга хэмжээг дутуу, 25 төсөл, арга хэмжээг огт оруулаагүй байна.

Сумдууд тухайн жилийн батлагдсан ажлын жагсаалтыг оруулж байгаа боловч ажил тус бүрийн хэрэгжилтийг дутуу оруулж байгаа нь нийтлэг байна. Сүмбэр сум ОНХС-ийн мэдээллийг удирдлага мэдээллийн системд огт оруулаагүй байдалтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон төвлөрүүлэн захирагчид “Шилэн дансны тухай хууль” болон “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийг тухай бүр мэдээлэх үүрэгтэй.

ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсныг шалгаж үзэхэд аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор мэдээлбэл зохих нийт 569 төсөл арга хэмжээнд 37,513.8 сая төгрөгийг баталсан байна. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгаж зөвлөмж өгч ажилласан.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Аймгийн өөрийн орлогын эх үүсвэр 582.5 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Зарим сумд ой, баяр наадам тэмдэглэх хандив, тусламжийн орлогыг өндрөөр төлөвлөсөн, мөн малын тоо толгойн татварыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн төвлөрүүлээгүйгээс гадна сумдын малын тоо толгойн албан татварын дансанд төвлөрсөн 357.3 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй төлөвлөгөө биелээгүй байна.
- Аймгийн ОНХС-аас хэрэгжих төсөл, хөтөлбөрийг аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулж төлөвлөсөн боловч нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй, сумд нь иргэдээс санал авч эрэмбэлэн сумын ИТХ-аар батлуулсан бөгөөд 2 сум иргэдээс санал аваагүй байна.
- Сумдын ОНХС-аас хэрэгжихээр батлагдсан ажлууд нь зураг, төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, 20.0 сая төгрөгөөс доош ажилд хяналтын төсөв хийлгэдэггүй, өөрсдийн багцаа үнээр бодит биш үнэлдэг, ижил төстэй ажлуудыг хувааж шууд худалдан авах аргаар олон салгаж баталсан байна.
- Сум орон нутагт худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны нарийн бичиг худалдан авах ажиллагааны баримт бичгийн стандарт, дэс дараалал, тавигдах шаардлагуудыг журмын дагуу хөтөлж ажиллаагүй байна.
- Сумд нь хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэхдээ төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэл гараагүй байхад 40-100 хувийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон, захиалагчийн зардлыг суутган тооцолгүй гүйцэтгэгчийг илүү санхүүжүүлсэн байна.
- Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоогүй, тооцоо судалгааг хангалттай хийгээгүйгээс төсөл, хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан тоног төхөөрөмж, техникүүд нь зориулалтын дагуу бүрэн ашиглагдаагүй, үр дүнгүй хэрэгжсэн байна.
- Хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн зүгээс хяналт тавьдаг боловч илэрсэн зөрчлийг арилгадаггүй, ажил хүлээлцэх комиссын актаар хүлээж авдаг байна.
- Аудитаар нийт 8,778.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 5 зөвлөмж, 635.8 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, 204.7 сая төгрөгийн 27 төлбөрийн акт, 8,560.4 сая төгрөгийн 75 албан шаардлага, 1,030.6 сая төгрөгийн зөрчил гаргасан 5 албан тушаалтанд хариуцлага тооцох албан бичигдлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Л.Төмөр-Чөдөр, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Уянга нарт зөвлөх нь:

- Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 7 дугаар зүйлийн 7.5-д заасан урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- Төсөл, хөтөлбөр батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангасан, тооцоо судалгаа хийгдэж, үр өгөөж нь тодорхой болсон ажлуудад санхүүжилт батлах

Аймгийн худалдан авах ажиллагааны газрын дарга С.Тамирт зөвлөх нь:

- Сумдын үнэлгээний хороонд заавар зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах

Сумдын Засаг дарга нарт:

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулж ажиллах,

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Ц.Хишигжаргал

О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Аудитор

Ч.Загдсүрэн

С.Намшир

Г.Хатанбаатар

Г.Ариун-Уянга

Холбогдох байгууллагын санал:

Аудитын тайлангийн төслийг холбогдох байгууллагуудын саналыг авахаар аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар зэрэг байгууллагуудад хүргүүлэв.



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41131 Төв аймаг, Туулхай сум, Ногоо 1 дүр тэр байр

Утас: 70273623, И-мэйл: tsx.dorlog@gov.mn

2025. 08. 25 № 07/1423

Тамгай _____-ны № _____

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА**

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд (ТӨА-2025/26-18-ШТА-ГА) хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Зөвлөмжийн хэрэгжилтийн дагуу хяналт тавьж, мөрдөж ажиллах болно.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.УЯНГА

• 4125021462



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Төв захиргааны II байр, 6 дугаар баг,
Зуунмод сум, Төв аймаг, 41105
Утас: 7755 3579,
Цахим шуудан: tuvprocurement@tov.gov.mn,
Цахим хуудас: to.spa.gov.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

2025.08.25 № 01/198
танай _____-ны № _____-т

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн
талаар

Төв аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцлаа.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас аудитаас өгөгдсөн дүгнэлтэд одоогоор өгөх тайлбаргүй. Цаашид өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр холбогдох арга хэмжээг авч хамтран ажиллахыг үүгээр илэрхийлж байна.

Жич: 2025 онд Сумд, захиалагч байгууллагууд Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2 удаагийн зөвлөмж, Аймгийн Засаг даргын албан даалгавар-1, танхимын 4 удаагийн сургалт, цахимаар 2 удаа, зөвлөн туслахаар 6 сумдад ажилласан болно.

ДАРГА

С.ТАМИР



4125020179